

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2020.07.22

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан”-г 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн ХЭГ/1503 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд шинжилгээ хийж, Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр ялган гаргасан болно. Шинжилгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн хэсэг, заалтыг хяналтаас хасах саналыг хавсаргав.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ХЭСЭГ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЛААР**

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 105 хуулийн 527 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс хяналтад авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 99 хуулийн 427 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 99 хуулийн 426 хэсэг, заалт буюу 80.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 12 /давхардсан тоогоор/ хуулийн 101 хэсэг, заалт буюу 19.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 1 хуулийн 1 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	105	527
2	Засгийн газраас ирүүлсэн	99	427
	Үүнээс:		
	- Хяналтад байгаа	99	426
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	1	1
3	Засгийн газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	12	101

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 99 хуулийн 427 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 67 хуулийн 250 хэсэг, заалт буюу 58.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 хуулийн 54 хэсэг, заалт буюу 12.6 хувь нь хэрэгжих шатанд, 18 хуулийн 36 хэсэг, заалт буюу 8.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 23 хуулийн 29 хэсэг, заалт буюу 6.8 хувь нь хэрэгжээгүй, 25 хуулийн 58 хэсэг, заалт буюу 13.6 хувь нь үнэлэх боломжгүй байна.

2.2. Монгол Улсын хуулиар Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн хэсэг, заалтын хэрэгжилт

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 15 хуулийн 79 хэсэг, заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 12 хуулийн 42 хэсэг, заалт буюу 53.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 2 хуулийн 18 хэсэг, заалт буюу 42.9 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 хуулийн 4 хэсэг, заалт буюу 9.5 хувь нь хэрэгжих шатанд, 8 хуулийн 10 хэсэг, заалт буюу 23.8 хувь нь хэрэгжээгүй, 2 хуулийн 10 хэсэг, заалт буюу 23.8 хувь нь үнэлэх боломжгүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/	Хэсэг, заалт	
	Тоо	Тоо	Хувь
Хяналтад авсан	15	79	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	12	42	53.2
Үүнээс:			
- бүрэн хэрэгжсэн	2	18	42.9
- хэрэгжих шатанд	3	4	9.5
- хэрэгжилт хангалтгүй	-	-	-
- хэрэгжээгүй	8	10	23.8
- үнэлэх боломжгүй	2	10	23.8

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 6 хуулийн 37 хэсэг, заалт буюу 46.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

№	Хуулийн нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт
1	Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /2012.05.22/	2 дахь хэсэг;
2	Нягтлан бодох бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга 2015.06.19/	22 дугаар зүйлийн 22.2; 22.6 дахь хэсэг;
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2019.03.22/	52 ¹ .3; 10 ¹ .2; 47.5; 55.2 дахь хэсэг;
4	Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга 2019.03.27/	8.1; 8.2; 8.5; 26.7; 29.8; 30.10; 33.3; 35.9; 38.9; 41.8; 46.4; 53.10; 58.7; 73.1; 79.5 дахь хэсэг;
5	Хувь хүний орлогын албан татварын тухай /Шинэчилсэн найруулга 2019.03.22/	5.11; 15.8; 23.11; 23.15; 24.4; 26.4; 28.5 дахь хэсэг;
6	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /Шинэчилсэн найруулга 2019.03.22/	6.10; 15.2; 19.11; 22.6; 23.10; 27.6; 29.4; 31.10 дахь хэсэг.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 238 заалтыг хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 55 тогтоолын 171 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 38 тогтоолын 118 заалт буюу 49.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 40 тогтоолын 120 заалт буюу 50.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 24 тогтоолын 53 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	70	238
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	55	171
	- Хяналтад байгаа	38	118
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	24	53

3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	40	120
---	---	----	-----

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 38 тогтоолын 118 заалтаас давхардсан тоогоор 30 тогтоолын 74 заалт буюу 62.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 11 тогтоолын 31 заалт буюу 26.3 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 9 заалт буюу 7.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.9 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 2.5 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

3.2.Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн 22 тогтоолын 56 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 9 тогтоолын 15 заалт буюу 26.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 9 тогтоолын 13 заалт буюу 86.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 1 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжээгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжилтийн мэдээ ирүүлэх хугацаа болоогүй байна.

УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтад авсан</i>	22	56	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	9	15	26.8
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	9	13	86.6
- <i>Хэрэгжих шатанд</i>	-	-	-
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	-	-	-
- <i>Хэрэгжээгүй</i>	1	1	6.7
- <i>Үнэлэх боломжгүй</i>	1	1	6.7

3.3. Мэдээнд гарсан зөрчил

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа дараах Улсын Их Хурлын 15 тогтоолын 41 заалт буюу 73.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

№	Улсын Их Хурлын тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2014.04.17 №30/	1.9; 1.13; 1.14 дэх заалт;
2	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2014.05.30 №39/	1 дэх заалт;
3	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай	1.1; 1.9 дэх заалт;

	/2015.02.17 №36/	
4	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2016.09.09 №47/	1.а; 1.б; 1.в; 1.г; 1.д; 2.а; 2.б; 2.в; 2.г; 2.д; 2.е; 3.а; 3.б дэх заалт;
5	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2016.11.17 №69/	1.3; 2.1; 4.2; 4.4; 4.5 дахь заалт;
6	Нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай /2018.01.12 №03/	1; 2 дахь заалт;
7	Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2018.06.21 №58/	1 дэх заалт;
8	Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2018.11.02 №80/	3; 4 дэх заалт;
9	Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц батлах орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай /2019.01.17 №07/	4 дэх заалт;
10	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2019.05.02 №53/	1; 3; 4 дэх заалт;
11	Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг батлах тухай /2019.05.30 №55/	2 дахь заалт;
12	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2019.06.06 №61/	4 дэх заалт;
13	Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай /2019.06.13 №67/	3 дахь заалт;
14	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2019.10.25 №84/	3 дахь заалт;
15	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2019.11.13 №89/	1; 2; 3; 4 дэх заалт;

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 99 тогтоолын 673 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 82 тогтоолын 420 заалт буюу 62.4 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн нь бүгд хяналтад байх заалтууд байна. Давхардсан тоогоор 47 тогтоолын 253 заалт буюу 37.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	99	673
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	82	420

	- Хяналтад байгаа	82	420
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	-	-
3	ЗГХЭГ-аас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	47	253

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 82 тогтоолын 420 заалтаас давхардсан тоогоор 65 тогтоолын 252 заалт буюу 60.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 47 тогтоолын 100 заалт буюу 23.8 хувь нь хэрэгжих шатанд, 20 тогтоолын 26 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 11 тогтоолын 28 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжээгүй, 12 тогтоолын 14 заалт буюу 3.3 хувь нь үнэлэх боломжгүй гэсэн мэдээ ирүүлсэн байна.

4.2.Төсвийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Төсвийн байнгын хорооны Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн 4 тогтоолын 15 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 4 тогтоолын 12 заалт буюу 80.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 3 тогтоолын 8 заалт буюу 66.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 2 заалт буюу 16.7 хувь нь хэрэгжээгүй, 2 тогтоолын 2 заалт буюу 16.7 хувь нь үнэлэх боломжгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	ТБХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтад авсан	4	15	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	4	12	80.0
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	3	8	66.6
- Хэрэгжих шатанд	-	-	-
- Хэрэгжилт хангалтгүй	-	-	-
- Хэрэгжээгүй	1	2	16.7
- Үнэлэх боломжгүй	2	2	16.7

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа 1 тогтоолын 3 заалт буюу 20.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

№	Төсвийн байнгын хорооны тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай /2013.04.16 №04/04/	1.5/; 1.6/; 1.7/ дахь заалт.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 2 хуулийн 17 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 9 тогтоолын 13 заалт, Төсвийн байнгын хорооны 3 тогтоолын 8 заалтыг хяналтаас хасах саналыг хавсралтаар хүргүүлэв.

Харин Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга 2019.03.27/-ийн 18 дугаар зүйлийн 18.18 дахь хэсгийг бүрэн хэрэгжээгүй гэж үзсэн тул хяналтад үлдээв.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хяналтад байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хангалтгүй ирүүлж байна. Тухайлбал, тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хяналтад байгаа Монгол Улсын 6 хуулийн 37 хэсэг, заалт буюу 46.8 хувь, Улсын Их Хурлын 15 тогтоолын 41 заалт буюу 73.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

2/ Цаашид хэрэгжилтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад үүрэг, чиглэл өгч ажиллах нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ИЙН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1.	<p>Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ 2019.03.27</p> <p>Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	<p>10.2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулах бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>16.7. Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эсэхийг Эрсдэлийн удирдлагын хороо шийдвэрлэх бөгөөд хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>17.3. Татварын харилцан тохирох журмыг Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, нэгдэн орсон олон улсын байгууллагаас тавигдах шаардлагад нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>19.4. Энэ хуулийн 19.1-д заасан байр агуулахад нэвтрэн орж мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийхтэй холбогдсон журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.</p> <p>19.5. Энэ хуулийн 19.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>Хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журмыг Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 292 дугаар тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.</p> <p>Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх журмыг Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 301 дугаар тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.</p> <p>Татварын харилцан тохирох журмыг Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 293 дугаар тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.</p> <p>Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/263 тоот тушаалаар баталсан “Татварын ногдлыг тодорхойлох, татвар хураах зорилгоор хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журам”-аар байр агуулахад нэвтрэн орж мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулж өгсөн.</p> <p>Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/263 тоот тушаалаар баталсан “Татварын ногдлыг тодорхойлох, татвар хураах зорилгоор хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журам”-аар Татварын улсын байцаагч татварын ногдлыг тодорхойлох болон татвар хураах зорилгоор татвар төлөгчийн байр агуулахад нэвтрэн орж мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх зэрэг нийтлэг ажиллагааг зохицуулж өгсөн.</p>

		35.11. Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны журмыг эрсдэлийн удирдлагын стандартад нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 304 тоот тушаалаар Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны журам батлан хэрэгжүүлж байна.
		36.3. Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох журмыг Сангийн сайдын 2019 оны 12-р сарын 27-ны өдрийн 294 дүгээр тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.
		40.4. Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журмыг Сангийн сайдын 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн 308 дугаар тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.
		46.9. Аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилж, чөлөөлнө.	Аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг томилж, чөлөөлөх асуудлыг Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны 466 дугаар тогтоолоор зохицуулсан.
		60.9. Хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журмыг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49, 50, 51, 52, 53, 54, 56 дугаар зүйлд заасныг жишиг болгон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журмыг Сангийн сайдын 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн 307 дугаар тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.
		68.7. Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журмыг Сангийн сайдын 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн 306 дугаар тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.
		71.3. Энэ хуулийн 71.1-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Татварын өрийг хураах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө татварын өрийн хэмжээнээс хамаарч татвар төлөгчид сануулах байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг авахтай холбогдсон журмыг Сангийн сайдын 2019 оны 304 дүгээр тушаалаар баталж, ХЗДХЯ-нд хүргүүлсэн.
		74.5. Татварын алба нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.	УИХ-аас 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн 201.1-д "Татварын алба нь бэлгэ, тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.",

			2019.03.22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн 74.5-т “Татварын алба нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.” гэж тус тус заасан. Дээрх заалтын дагуу Татварын ерөнхий газрын даргын 2019.10.29-ний өдрийн А/191 дүгээр тушаалаар “Татварын албаны бэлгэ тэмдгийн тэмдгийн загвар, бэлгэ тэмдгийг хэрэглэх журам”-ыг батлан, Оюуны өмчийн газар бүртгүүлэхээр хүргүүлсэн. Тус газар нь татварын албаны бэлгэ тэмдгийг барааны тэмдгийн хайлтын санд 2019.12.16-ны өдөр бүртгэснээ 2019.12.16-ны өдрийн 3/809 тоот албан бичгээр уламжилсан байна.
		78.7. Энэ зүйлийн зөвлөмж авах хүсэлтэд тавигдах шаардлага, хүсэлтийн маягт, зөвлөмжийн маягт, зөвлөмжийг хүчингүй болгох, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Зөвлөмж авах хүсэлтэд тавигдах шаардлага, хүсэлтийн маягт, зөвлөмжийн маягт, зөвлөмжийг хүчингүй болгох, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон журмыг Сангийн сайдын 2019 оны 295 дугаар тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.
		80.2. Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Төсвийн тухай хуульд нийцүүлэн батална.	Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох болон Татварын улсын байцаагч хувцас, хэрэглэл хэрэглэх, цол, түүний нэмэгдэл олгох журмыг Сангийн сайдын 2019 оны 311 дүгээр тушаалаар баталсан.
		80.5. Татварын улсын байцаагч хувцас, хэрэглэл хэрэглэх, цол, түүний нэмэгдэл олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох болон Татварын улсын байцаагч хувцас, хэрэглэл хэрэглэх, цол, түүний нэмэгдэл олгох журмыг Сангийн сайдын 2019 оны 311 дүгээр тушаалаар баталсан.
2.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /Шинэчилсэн найруулга/ 2019.03.22 /Энэ хуулийг 2020.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/	30.6. Энэ хуулийн 30.4-т заасан орлогод албан татвар ногдуулах журам, газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлалыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Энэ хуулийн 30.4-т заасан орлогод албан татвар ногдуулах журам болон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлалыг Сангийн сайдын 2019 оны 302, 303 дугаар тушаалаар баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн.
2 хуулийн 17 хэсэг, заалт			

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2015.02.17 №36	1.8. Боловсрол, эрүүл мэндийн салбарын засаглалыг сайжруулж улс төрөөс хараат бус, бие даасан байдлыг бүрдүүлэх, эдгээр салбарын ажилчдын цалин, урамшууллыг мэргэжлийн зэрэг, ур чадварыг харгалзан тооцох тогтолцоог бүрдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих болон хариуцлагыг сайжруулах чиглэлээр судалгаа хийж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.	Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дах хэсэгт заасан тусламж үйлчилгээний төлбөрийг төрөөс хариуцахаар баталсан бөгөөд энэ тусламж үйлчилгээг өртөг ойролцоо оношийн бүлгээр санхүүжүүлэхээр холбогдох тооцоо, судалгааг Сангийн яам, төслийн багтай хамтран 2019 оны 12 сард зохион байгуулж дууссан. Судалгаа, тооцоололд үндэслэн Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019.12.09-ны өдрийн 256/А/561 дугаар бүхий “Улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, өртгийн жин, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, хяналт тавих журам батлах тухай” тушаал батлагдсан. Эмч, эрүүл мэндийн ажилтнуудын ажлын ачаалалтай уялдсан цалин хөлсний тогтолцоог бий болгох зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны үнэлгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулж, үнэлгээний тайланд үндэслэсэн цалин хөлсний тогтолцоог боловсруулан зэрэглэлийг 2-3 ахиулж 2019 оны Засгийн газрын 25 дугаар тогтоолоор батлуулсан.
2.	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016.11.17 №69	3.2. Засгийн газрын тусгай сангуудын авлагыг барагдуулах, тусгай сан тус бүрийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг тооцох, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Тариаланг дэмжих сангийн хөрөнгийн бодит өгөөж, ажлын байр нэмэгдүүлсэн байдал, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний тоо хэмжээ, экспортод үзүүлсэн үр дүн, нөлөөллийн талаар судалгаа хийж, дүнг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулах;	"Төсвийн урсгал зарлагыг бодитой тооцох зорилгоор төсөвт байгууллагын дотоод албан томилолтын зардлын жишиг норм, ЕБС-ийн багшаас бусад албан хаагчийн орон тооны норматив, төрийн үйлчилгээний албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох тооцон олгох аргачлал, төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдлийн журам, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй болон нэмэлт эмчилгээ үйлчилгээний жишиг үнэ, тусламж үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн боловсруулаад байна. Түүнчлэн нэгдсэн төсвийн урсгал зардлын талаар баримтлах 8 зарчмыг тогтоож үр дүнг нь Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусган УИХ-аар батлууллаа. Цаашид эдгээр зарчмуудыг 2018-2020 оны жилийн төсвийн төсөл боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавихад мөрдлөг болгон ажиллана. Төсвийн урсгал зарлагыг бодитой тооцох зорилгоор төсөвт байгууллагын дотоод албан томилолтын зардлын жишиг нормыг Сангийн сайдын

			<p>2018.12.27-ны өдрийн 301 тоот тушаалаар батлуулсан, ЕБС-ийн багшаас бусад албан хаагчийн орон тооны нормативийг БСШУССайд, ССайдын хамтарсан А/024/11 тоот тушаалаар батлуулсан, Төрийн албан хаагчид шагнал олгох, мөнгөн урамшуулал олгох ЗГ-ын 2019.01.09-ний өдрийн “Журам батлах тухай” 5 дугаар тогтоол, Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох ЗГ-ын 2019 оны “Журам батлах тухай” 6 дугаар тогтоол, Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох ЗГ-ын 2019 оны “Журам батлах тухай” 7 дугаар тогтоол, Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох ЗГ-ын 2019 оны “Журам батлах тухай” 8 дугаар тогтоол, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох ЗГ-ын 2019 оны “Журам батлах тухай” 9 дүгээр тогтоол, орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлалыг “Аргачлал шинэчлэн батлах тухай” ЗГ-ын 2019 оны 445 дугаар тогтоолуудыг тус тус батлуулж төсвийн шатлал бүрт орлого, зарлагын бодитой тооцох аргачлал бий болгосон. "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад урсгал зардлыг 107.3 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардалд 55.6 тэрбум төгрөгөөр, гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал 14.4 тэрбум төгрөгөөр төсөвлөж баталсан байна. ХХААХҮСайдын багцын зарим байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэл, хүрсэн үр дүнд дүн шинжилгээ хийж, удирдлагад танилцуулсан. 2017 оны төсвийн гүйцэтгэлээр урсгал зардал 99.5 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 48.9 тэрбум төгрөг байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад хамаарах зарим байгууллагын төсвийн гүйцэтгэлийн хүрсэн үр дүнгээс харуулбал ЖДҮХСан 2009-2017 оны хооронд Төсөл сонгон шалгаруулах хороо болон дэд хороонд хандан 26,454 төсөлд 3 их наяд 850.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн төсөл ирүүлсэн бөгөөд үүнээс нийт эрэлтийн 18% буюу 7536 төсөлд 835.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт олгож, хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт авсан иргэн, аж ахуй нэгжүүд Улаанбаатар хотод 13,341 ажлын байр хадгалж, 19,600 ажлын байр шинээр нэмэгдүүлж, орон нутагт 12,076 ажлын байр хадгалж 21,028 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн бол нийт 25,417 ажлын байр хадгалж, 40,628 ажлын байр шинээр нэмэгдүүлж, хүнсний үйлдвэр, хөнгөн үйлдвэр, газар тариалан, мал аж ахуй, барилгын үйлдвэр, зоорь, био технологи, худалдаа үйлчилгээ, дахивар, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт авсан иргэн, аж ахуй нэгжүүд 1605 үйлдвэр өргөтгөж, 621 үйлдвэр шинээр байгуулсан байна.</p>
--	--	--	---

3.	Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2017.11.14 №69	<p>1.1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад “сахилга, хариуцлага, ажлын үр дүнг урамшуулах” зориулалтаар батлагдсан хөрөнгийг зарцуулахтай холбогдуулан төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог бий болгох, энэ талаар холбогдох журам баталж мөрдүүлэх.</p>	<p>“Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг тус тус мөрдлөг болгон ажиллаж байна.</p>
		<p>1.2. Газрын тухай хуульд нэмэлт оруулсантай холбогдуулан газрын зэрэглэл, тэдгээрийн нэг гектарын суурь үнэлгээ, жилийн төлбөрийн дээд, доод хязгаарыг шинэчлэн тогтоох.</p>	<p>"Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал батлах тухай" Засгийн газрын 2018 оны 181 дүгээр тогтоол, "Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг тус тус батлуулсан.</p>
		<p>1.3. Газрын суурь үнэлгээг Засгийн газар тодорхой хугацаанд шинэчлэн тогтоож, нийтэд заавал зарлаж байх үүргийг Газрын төлбөрийн тухай хуулиар нарийвчлан тогтоох хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.</p>	<p>Газрын суурь үнэлгээг Засгийн газар тодорхой хугацаанд шинэчлэн тогтоож, нийтэд заавал зарлаж байх үүргийг Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр УИХ-аар батлуулсан. Хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.</p>
		<p>1.4. улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний байршил, хүчин чадлаас хамааруулан төсөвт өртгийн зөрүүг нягталж, батлагдсан төсөвт өртөгт багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулах.</p>	<p>1.1 2018 оны батлагдсан төсвийн хүрээнд тодотгол хийхгүй байх зарчмыг баримтлан Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 202, 2018 оны 140, 186 дугаар тушаалуудаар зохицуулалт хийж, биелэлтийг хангаж ажилласан. 1.2 Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан. 1.3 Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр салбарт хэрэгжиж буй төслүүдийн арилжааны банкин дахь төгрөгийн дансыг Төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлсэн. Цаашид Арилжааны банкинд шинээр данс нээхгүй байхад анхаарч ажиллаж байна. 1.4 Барилга, хот байгуулалтын сайдын багцын хэмжээнд 2018 онд нийт 2,158.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан бөгөөд орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлж ажилласан.1.5 УИХ-аас 2017.11.10-ны өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар батлагдсан газрын эрх шилжсэний төлбөрийг аймаг, нийслэлийн хэмжээнд орон нутгийн төсөвт</p>

			төвлөрүүлж ажилласан. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/10, А/11, А/13, А/23, А/24, А/25, А/26, А/27, А/28, А/29, А/30, А/31, А/42, А/44, А/45, А/47, А/48, А/58, А/88, А/97, А/115, А/130, А/135 дугаар тушаалаар Үнэлгээний хороог тус тус байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Тайлант хугацаанд улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан 109 төсөл, арга хэмжээний 99 хувь буюу 108 тендерийг зарласан ба үүнээс 97 хувь буюу 106 нь гэрээ байгуулагдсан, 2 нь зарлагдсанаас нээгээгүй, 1 тендер нь өмнө хийгдсэн ажил тул зарлагдаагүй. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын багцаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх шийдвэрийг тушаал гарсан тухай бүр буюу яамны 2018.01.17-ны өдрийн 03/133, 2018.01.26-ны өдрийн 03/349, 2018.02.26-ны өдрийн 03/672, 2018.03.05-ны өдрийн 03/759, 2018.03.07-ны өдрийн 03/801, 2018.04.17-ны өдрийн 04/1368, 2018.08.17-ны өдрийн 03/3227 тоот албан бичгүүдээр хүргүүлж ажилласан.
4.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.02.02 №17	1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор Улсын Их Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан 2018 оны улс, орон нутгийн төсвийн орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрийг батлагдсан хэмжээнээс нэмэгдүүлэх боломжит бүх арга хэмжээг авч, улс, орон нутгийн төсвийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-г, аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	УИХ-аас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар татварын хувь хэмжээг бууруулсан боловч УИХ-ын 2018 оны 17 дугаар тогтоолоор өгөгдсөн үүргийг бүрэн хэрэгжүүлж хувь хүний орлогын албан татварын орлогын батлагдсан төлөвлөгөөг 52.7 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар давуулан биелүүлж нийт 850.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж ажиллалаа.
5.	Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2018.06.07 №43	1. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдөр баталсантай холбогдуулан бүх салбарт мөрдөгдөж байгаа зардлын норм, норматив, стандартыг валютын ханш, зах зээл дэх бараа, ажил үйлчилгээний үнийн өөрчлөлт, техник, технологийн дэвшлийг үндэслэн шинэчлэх ажлыг зохион байгуулах, урсгал болон	Сангийн сайдын 2018.12.25-ны өдрийн “Журам болон аргачлал батлах тухай” 295 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх, сонгох аргачлалыг боловсруулан баталсан. "Төсвийн урсгал зарлагыг бодитой тооцох зорилгоор төсөвт байгууллагын дотоод албан томилолтын зардлын жишиг норм, ЕБС-ийн багшаас бусад албан хаагчийн орон тооны норматив, төрийн үйлчилгээний албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох тооцон олгох аргачлал, төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдлийн журам, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй болон нэмэлт эмчилгээ үйлчилгээний жишиг үнэ, тусламж

		хөрөнгийн зардлын төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлийн хяналт хийхэд эдгээр норм, норматив, стандартыг хэрхэн ашиглах талаар холбогдох хуульд заасан журам, зааврыг баталж мөрдүүлэх, шаардлагатай бол хуульд өөрчлөлт оруулах төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.	үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн боловсруулаад байна. ЕБС-ийн багшаас бусад албан хаагчийн орон тооны нормативийг БСШУССайд, ССайддын хамтарсан А/024/11 тоот тушаалаар батлуулсан, Төрийн албан хаагчид шагнал олгох, мөнгөн урамшуулал олгох Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн “Журам батлах тухай” 5 дугаар тогтоол, Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 6 дугаар тогтоол, Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 7 дугаар тогтоол, Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 8 дугаар тогтоол, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 9 дүгээр тогтоол, орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлалыг “Аргачлал шинэчлэн батлах тухай” ЗГ-ын 2019 оны 445 дугаар тогтоолуудыг тус тус батлуулж төсвийн шатлал бүрд орлого, зарлагын бодитой тооцох аргачлал бий болгосон.
6.	Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2018.11.02 №80	1/ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллах;	Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1293 төсөл, арга хэмжээний 1,698.2 тэрбум төгрөг батлагдсанаас, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1281 төсөл, арга хэмжээний 1,553.4 тэрбум төгрөг, “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтөд 12 төсөл, арга хэмжээний 144.7 тэрбум төгрөг тус тус батлагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 1281 төсөл, арга хэмжээнээс 908 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжиж, 373 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжсэн бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 1,560.4 тэрбум төгрөг буюу 91.9 хувийн биелэлттэй байна. ХЭЗГ-Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 1,037.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, шинээр эхлэх 908 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажилласан.
7.	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний	2. Төрийн захиргааны албан хаагчид 2019 онд олгох зэрэг дэвийн нэмэгдлийг баталсан төсвийн хэмжээнд багтаан зохицуулж, цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын 2019.02.01-ний 21 дүгээр тогтоол, “Журам батлах тухай” Засгийн газрын 2018.12.19-ний өдрийн 382 дугаар тогтоол, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн 275 дугаар

	нэмэгдэл олгох журам батлах тухай 2019.02.01 №21	төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.	тогтоол, “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 07 дугаар сарын 03-ны өдрийн 277 дугаар тогтоол, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 24 дүгээр тогтоолын 1, 9 дүгээр хавсралтыг хэрэгжүүлж байна.
8.	Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай 2019.05.02 №41	5. Улсын тусгай хамгаалалтад авч байгаа газруудын хамгааллын менежментийг шинээр бүтэц орон тоо, цалингийн санг нэмэгдүүлэхгүйгээр баталсан орон тоо, төсөвт багтаан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.	2019 оны 41 дүгээр УИХ-ын тогтоолоор 22 газрыг шинээр болон өргөтгөлөөр улсын тусгай хамгаалалтад авсантай холбогдуулж, Улсын тусгай хамгаалалтад авч байгаа газруудын хамгааллын менежментийг шинээр бүтэц орон тоог шинэчлэн “Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо болон сургалт, мэдээллийн төвүүдийн байршлыг шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020.02.12-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар баталсан байна.
9.	Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019.11.28 №96	2.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгөөр олгосугай. 2.2/ хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоход шаардагдах санхүүжилтийг цаашид жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх.	Шинэ коронавирусийн дэгдэлт өндөр байгаа энэ цаг үед Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу 0-18 насны хүүхэд бүрт сар бүр олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн 4, 5, 6 дугаар сард 50 хувиар нэмэгдүүлэн олгож байна. Журамд өөрчлөлт оруулан, оноо харгалзахгүй хүсэлт гаргасан хүүхэд бүрт олгох зохицуулалт хийсэн. 2020 оны улсын төсөвт хүсэлт гаргасан хүүхэд бүрд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоход зориулж 240 тэрбум төгрөгийн хөрөнгийг тусгасан. 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлд бүх хүүхдэд хүүхдийн мөнгийг олгохоор тооцон хөрөнгийг тусган, саналаа хүргүүлсэн.
9 тогтоолын 13 заалт			

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ
БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1.	Чиглэл өгөх тухай 2014.12.02 №15	1.3/ Төсвийн тухай хуулийн 60.3 дахь хэсгийг зөрчсөн тухайн шатны Засаг даргад мөн хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт заасныг үндэслэн огцруулах хүртэл арга хэмжээ авах, Төсвийн тухай хуулийн 24.4 дэх хэсгийг зөрчсөн холбогдох албан тушаалтанд мөн хуулийн 70.3-т заасан сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг тус тус авах;	Сангийн сайдтай аймаг, нийслэлийн байгуулсан гэрээний хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан. 2008 оноос санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил болон шалгалтын дүнг үндэслэн эрсдэлтэй байгууллагын судалгаа гарган ажиллаж байна. Дээрх эрсдэлтэй байгууллагын судалгааг ашиглан санхүүгийн хяналт шалгалтад хамруулах байгууллагыг сонгон тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж хяналт шалгалт хийж байна. 2019 онд эрсдэлтэй гэж тодорхойлогдсон төсөвт болон төрийн өмчийн оролцоотой 19 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, шалгалтын дүнг Сайдын дэргэдэх “Дотоод аудитын хорооны”-ны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, тухайн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Шалгалтын дүнгээр нийт 353.8 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэнд улсын байцаагчийн акт тогтоож, албан шаардлага өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна.
2.	Засгийн газарт чиглэл өгөх тухай /НББСШУБХ/ТБХ/ 2016.03.26 №09/03	1.2/ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амьдралд бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусган ажиллах, сургалтын хөтөлбөрийг дараагийн шатны сургалтын байгууллагын агуулгад шилжихэд дөхөмтэй байхаар шинэчлэн боловсруулах, мэргэжлийн сургалтад хамрагдаж зохих ур чадвар эзэмшснийг гэрчлэх чадамжийн гэрчилгээ, сертификат, мэргэжлийн үнэмлэх олгох;	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд нийт 37.806 суралцагч байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй 551 суралцагч 44 сургалтын байгууллагад суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амьдралд бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох дагнасан сургалтын 4 байгууллагад нийт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын 51.0 хувь нь, үлдсэн 49.0 хувь нь бусад 40 сургалтын байгууллагад суралцаж байна. - Сэргээн Засалт, Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн Мэргэжлийн Боловсрол, Ур Чадвар Олгох Сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 118 суралцагч 9 мэргэжлээр, - Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны дэргэдэх МСҮТ-дэд 94 суралцагч 7 мэргэжлээр, - Энэрэл МСҮТ-дэд 60 суралцагч 4 мэргэжлээр, - Анима Политехник коллежид 7 суралцагч 3 мэргэжлээр тус тус суралцаж

		<p>мэргэжил, ур чадвар эзэмшиж байна. Дээрх сургалтын байгууллагууд тусгай сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор мэргэжил сурталчилах өдөрлөгүүдийг жил бүр зохион байгуулж элсэлт авдаг. Мөн Сэргээн Засалт, Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн Мэргэжлийн Боловсрол, Ур Чадвар Олгох Сургууль 2,5 жилийн мэргэжлийн чадамжийн нэгжийн агуулгыг ПК-ийн сургалтын хөтөлбөртэй агуулгыг дүйцүүлж, дэвшин суралцах хүсэлтэй суралцагчийг техникийн боловсрол олгохоор Монгол Солонгосын ПК-д дэвшүүлэн суралцуулж байна. “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”, суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ 2019 онд Засгийн газрын 12 дугаар тогтоолоор 100.0 мян.төг, 2020 онд 44 дүгээр тогтоолоор 200.0 мян.төгрөг болж шинэчлэгдэн батлагдсан.</p>	
	<p>1.5/ Бүх шатны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах асуудлыг Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусгаж, үүрэгжүүлж ажиллуулах;</p>	<p>Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэмд заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай үр дүнгийн гэрээг жил бүр байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус гэрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааганд дэмжлэг үзүүлж ажиллах тухай заалтыг оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
	<p>1.9/ Их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй оюутны тоог нарийвчлан гаргах мэдээллийн маягтай болох, дээрх сургуулиудын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, үйлчилгээ үзүүлэх төвийг бий болгох;</p>		<p>Мэргэжлийн боловсрол, сургалтын 80 байгууллагад 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд нийт суралцагчид 37806 байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 551, үүнээс эмэгтэй суралцагч 251 байна. Хөгжлийн бэрхшээлийн ангиллаар авч үзвэл харааны бэрхшээлтэй 144 суралцагч байгаа бөгөөд үүнээс эмэгтэй 56, ярианы бэрхшээлтэй 58, үүнээс эмэгтэй 22 суралцагч, сонсголын бэрхшээлтэй 56, үүнээс эмэгтэй 24 суралцагч, хөдөлгөөний бэрхшээлтэй 127, үүнээс эмэгтэй 63 суралцагч, сэтгэцийн бэрхшээлтэй 56, үүнээс эмэгтэй 23 суралцагч, бусад төрлийн бэрхшээлтэй суралцагч 110 байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоон мэдээлэл тухайн хичээлийн жилийн статистик маягтын үзүүлэлтээр гардаг.</p>
	<p>1.14/ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд саадгүй зорчих зам, орц, гарцыг ерөнхий боловсролын тусгай сургууль, цэцэрлэгийн орчинд бий болгож, таних тэмдэг байршуулж, гадны автомашин</p>		<p>2019 оны СХЗГ-ын даргын С/40 тоотой “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын Ерөнхий шаардлага” MNS6782:2019, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага” MNS6799:2019 зэрэг стандарт батлуулав. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн</p>

		зогсохгүй байхаар журамлах;	өгсөн чиглэлийн дагуу ЗТХЯ-ны санаачилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 29, 116 дугаар тусгай сургууль, 186 дугаар тусгай цэцэрлэгийн гаднах орчинг холбогдох стандартын дагуу тохижууллаа. Энэ арга хэмжээнд 100 гаруй сая төгрөгийг бусад яамд, байгууллагуудын хандиваар босгон зарцуулсан болно.
3.	Чиглэл өгөх тухай 2017.02.07 №03	1.1/ Улсын төсвийн нэгдмэл байдлыг хангах, тусгай сангуудын зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох, үр дүнг дээшлүүлэх, хоорондын уялдаа холбоог сайжруулах, давхардлыг арилгах, сангуудын зохицуулалтыг нэг хуулиар зохицуулах зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх.	Тус яам Засгийн газрын тусгай сангууд болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй зээл, батлан даалт, санхүүгийн дэмжлэгийн ил тод байдлыг хангах, хариуцлагатай, хүртээмжтэй болгох, эрсдэлийг бууруулж, үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулах болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа болно. Төсвийн хөрөнгөөр санхүүждэг, санхүүгийн дэмжлэг, зээл олгодог сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019.02.27-ны өдрийн 87 дугаар тогтоол батлуулсан. Уг тогтоолд даалгасны дагуу Улсын төсвийн нэгдмэл байдлыг хангах, тусгай сангуудын зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох, үр дүнг дээшлүүлэх, хоорондын уялдаа холбоог сайжруулах, давхардлыг арилгах, сангуудын зохицуулалтыг нэг хуулиар зохицуулах зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр УИХ-аар батлуулсан.
		1.2/ Тусгай сангийн үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, санхүүгийн эх үүсвэрийг хуулиар тодорхойлсон заалт бүрээр бүрдүүлээгүй, сангийн хөрөнгийг хууль бусаар зарцуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох.	“Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолын 6 дугаар заалтаар улсын төсвийг хохиролгүй болгох, мөн ажлын хариуцлага алдсан төрийн албан хаагчид холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байх үүргийг холбогдох Засгийн газрын гишүүдэд өгсөн болно.
		1.3/ Тусгай сангуудад үүссэн өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг улирал тутам тус Байнгын хороонд танилцуулах.	“Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” ЗГ-ын 2019 оны 87 дугаар тогтоолын 6 дугаар заалтаар хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах шат дараалсан арга хэмжээ авч, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгжүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах зэрэг арга хэмжээ авахыг холбогдох ЗГ-ын гишүүдэд даалгасан болно.
3 тогтоолын 8 заалт			

Танилцуулга бэлтгэсэн: ХШҮХ-ийн референт Б.Нандингэрэл